

ҮАГ

Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил,
үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудит

2006 оны
1 дүгээр сар

**ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ УГТВАР
НӨХЦӨЛ БҮРЭН БҮРДЭЭГҮЙ,
АЖЛЫН ЯВЦ УДААШРАЛТАЙ БАЙНА**

Чөлөөт бүс байгуулах ажлын явц, үр дүн

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур	3
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	3
Аудитын дүн	Ерөнхий зүйл	5
	Чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө үр ашигтай, үр нөлөөтэй боловсруулагдсан эсэх	6
	Чөлөөт бүсийн удирдлага үр ашигтай, үр нөлөөтэй ажиллаж буй эсэх	8
	Чөлөөт бүсийн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн эсэх	11
Дүгнэлт		13
Санал	ҮХЯ-ны санал	14
	“Алтанбулаг” ХЧБ-ийн ЗАА-ны санал	15
	“Замын-Үүд” ЭЗЧБ-ийн ЗАА-ны санал	18
ҮАГ-ын тайлбар		21
Зөвлөмж		23
Бусад	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	24

Товчилсон үгийн тайлбар:

- УИХ – Улсын Их Хурал
- ҮАГ – Үндэсний аудитын газар
- ҮХЯ – Үйлдвэр, худалдааны яам
- СЭЗЯ – Санхүү, эдийн засгийн яам
- ХЧБ – Худалдааны чөлөөт бүс
- ЭЗЧБ – Эдийн засгийн чөлөөт бүс
- ЗАА – Захирагчийн ажлын алба
- ТНБД – Төрийн нарийн бичгийн дарга

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

ҮАГ-ын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсад чөлөөт бүс байгуулах ажлын явц, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитаар “Алтанбулаг” худалдааны, “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажлын явц, үр дүнг дор дурдсан зорилт, дэд зорилтын дагуу шалгаж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын зорилт:

Чөлөөт бүс байгуулах ажлын явц, үр дүн

Дэд зорилтууд:

1. Чөлөөт бүсийн мастер болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө үр ашигтай, үр нөлөөтэй боловсруулагдсан эсэх;
2. Чөлөөт бүсийн удирдлага үр ашигтай, үр нөлөөтэй ажиллаж буй эсэх;
3. Чөлөөт бүсийн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн эсэх.

Дээрх зорилтын хүрээнд “Алтанбулаг” ХЧБ ба “Замын-Үүд” ЭЗЧБ-ийн ЗАА-ны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө, төсөл, түүний хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбогдох баримт, мэдээ, тайланг уншиж танилцан, чөлөөт бүсүүдийн ЗАА-ны удирдлага, ажилтнууд болон ҮХЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай ярилцаж, тайлан, мэдээ гаргуулан, аудитын шинжилгээний болон нарийвчилсан горимын дагуу сорилт, дүн шинжилгээ хийв.

Аудитад ашигласан шалгуур

Дараахь хууль, эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа:

- Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал;
- Чөлөөт бүсийн тухай хууль;
- “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль;
- “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Холбогдох бусад хууль, эрхийн актууд.

Аудитын стандартын талаархи мэдээлэл

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-2/2005/10-ГА гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болголоо.

Ерөнхий зүйл

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүгнэлтийг дэмжих нотлох зүйлс, холбогдох бусад баримт мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг УАГ-ын хоёрдугаар хэлтсийн дарга О.Мэндбаяр хянан удирдаж, ахлах аудитор М.Давааням, аудитор Ц.Баттуяа нар 2005 оны 10 дугаар сарын 14-нөөс 12 дугаар сарын 5-ны өдрүүдэд гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Ерөнхий зүйл

“Алтанбулаг” ХЧБ

УИХ-ын 1995 оны 87 дугаар тогтоолоор “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг баталсан. Мөн УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”-д зарим бүс нутагт эдийн засаг, худалдааны чөлөөт бүс бий болгон хөгжүүлэх талаар тусгагдсаны дагуу УИХ-ын 1996 оны 65 дугаар тогтоолоор “Алтанбулаг” ХЧБ байгуулах бэлтгэл ажлыг эрчимжүүлэхийг Засгийн газарт даалгажээ.

Үүнээс 6 жилийн дараа буюу 2002 онд “Чөлөөт бүсийн тухай”, “Алтанбулаг” ХЧБ-ийн эрх зүйн байдлын тухай” хууль батлагдан улмаар УИХ-ын 2002 оны 38 дугаар тогтоолоор “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байгуулахаар шийдвэрлэсэн байна.

УИХ-ын 2003 оны 15 дугаар тогтоолоор “Алтанбулаг” ХЧБ-ийн хилийн заагийг Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт 500 га талбай бүхий газар нутагтай байхаар тогтоожээ.

Засгийн газрын 2003 оны 54 дүгээр тогтоолоор БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгосон 4,0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөс 1,5 сая долларыг тус чөлөөт бүсийн эхний ээлжийн барилга байгууламж буюу хамгаалалтын хашаа, харуулын байр, ЗАА-ны контор, дэд бүтцийн барилга байгууламж барих зэрэгт зарцуулахаар шийдвэрлэжээ. Гэвч БНХАУ-ын Элчин сайдын яамнаас ирүүлсэн ноот бичгийн дагуу энэ 1,5 сая ам.долларыг өөр зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэн тул тус ХЧБ-ийн хувьд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн өөр эх үүсвэр олох шаардлага гарчээ.

ҮХ-ны сайдын 2004 оны 3 дугаар тушаалаар “Алтанбулаг” ХЧБ-ийн үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер зарласан боловч шаардлага хангасан санал ирээгүй байна.

Засгийн газрын 2005 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар “Алтанбулаг” ХЧБ-ийг байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч сонгох талаар хэлэлцэж, “Алтанбулаг” ХЧБ-ийг байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгох шалгуур үзүүлэлт, менежментийн гэрээ байгуулахад тавих ерөнхий шаардлагыг баталж мөрдүүлэхийг ҮХ-ны сайдад зөвшөөрсөн байна.

“Замын-Үүд” ЭЗЧБ

2003 оны 6 дугаар сард “Замын-Үүд” ЭЗЧБ-ийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан бөгөөд УИХ-ын 2004 оны 17 дугаар тогтоолоор “Замын-Үүд” ЭЗЧБ байгуулахаар шийдвэрлэж, газрын хэмжээ, бүсийн хилийн заагийг тогтоожээ.

Аудитын дүн

“Замын-Үүд” ЭЗЧБ-ийг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн цэс дотор 900 га талбайтай, Улаанбаатараас 780 км, Сайншанд хотоос 230 км, БНХАУ-ын Эрээн хотоос 8 км-т байхаар заажээ.

“Замын-Үүд” ЭЗЧБ-ийг байгуулж, хөгжүүлэх, үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер шалгаруулалт 2004 оны 2 дугаар сараас явагдаж, Их Британий “Вест Парадайз” (“West Paradise”) компани шалгарчээ.

Чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө үр ашигтай, үр нөлөөтэй боловсруулагдсан эсэх

“Алтанбулаг” ХЧБ

ҮХ-ны сайдын 2002 оны 116 дугаар тушаалаар “Алтанбулаг” ХЧБ-ийн мастер төлөвлөгөө, ерөнхий дэд бүтэц, байршлын төсөл боловсруулахаар шийдвэрлэсэн байна.

ҮХЯ “Алтанбулаг” ХЧБ-ийн хөгжлийн ерөнхий төсөл буюу мастер төлөвлөгөө, Алтанбулаг суурингийн болон “Алтанбулаг” ХЧБ-ийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус тус боловсруулах талаар “МИПС” ХХК-тай (туслан гүйцэтгэгч нь “Идеал групп” ХХК) 2003 оны 2 дугаар сард 200,0 сая төгрөгийн гэрээ байгуулжээ.

Энэхүү гэрээний 1.4-т “Гүйцэтгэгч өөрийн хийсэн ажилд үнэлэлт дүгнэлт гаргуулах, заавар зөвлөгөө авах чиглэлээр олон улсын туршлагыг судалж, гадаадын мэргэжилтэн, зөвлөх авч ажиллуулсан байна”, 2.3-т “Гүйцэтгэгч нь ... 6 хувь боловсруулж, 2003 оны 6 дугаар сарын 1-ний дотор дуусган, захиалагчид хүлээлгэн өгнө”, 3.6-т “Гүйцэтгэгч нь гэрээний 2.3 дахь заалтын хугацаанд ажлаа гүйцэтгэж дуусгаагүй нөхцөлд төлбөрийн дүнгээс хэтэрсэн хоног тутам 0,3 хувийн алданги төлнө”, 4.4-т “Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хийж, гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагуудын үнэлэлт, дүгнэлтийг гаргуулж хавсаргасан байна” гэж заасан нь бүрэн биеллээгүй байхад ҮХЯ-ны газрын дарга Д.Галсандорж, “Алтанбулаг” ХЧБ-ийн албаны дарга Д.Эрдэнэбат нар 2003 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр гэрээт ажлыг (3 хувь) хүлээн авч, акт үйлдэн, ажлын хөлсөнд 185,0 сая төгрөг төлжээ.

Гэтэл Дэд бүтцийн сайдын 2003 оны 273 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2003 оны 10 дугаар сарын 15-ны өдөр (гэрээт ажлыг акт үйлдэж хүлээж авснаас хойш 1 сарын дараа) “Идеал групп” ХХК-ний боловсруулсан “Алтанбулаг” ХЧБ-ийн ерөнхий төлөвлөгөө, Алтанбулаг сумын ерөнхий төлөвлөгөөнд улсын экспертизийн дүгнэлт гаргаж, бүгд 43 алдаа зөрчлийг арилгах шаардлагатай гэж дүгнэжээ.

Аудитаар гэрээний нөхцөлийн дагуу гэрээт ажлыг хугацаа хожимдуулсны алдангийг тооцож, 49,2 сая төгрөгийг гүйцэтгэгч “МИПС” ХХК –иар нөхөн төлүүлэхийг ЗАА-ны удирдлагад хариуцуулж, төлбөрийн акт тогтоосон.

Аудитын дүн

Мастер төлөвлөгөөг чөлөөт бүсийг үүсгэн байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх менежментийн чухал арга, өдөр тутмын үйл ажиллагааны удирдамж болох баримт бичиг гэж тодорхойлжээ. Уг баримт бичигт “Алтанбулаг” ХЧБ-ийн үйл ажиллагааг 2003-2004 он, 2005-2010 он, 2010-2015 он гэсэн үе шаттай авч үзсэн ба алсдаа Сүхбаатар-Алтанбулагийн чөлөөт бүс болгон өргөтгөх чиглэлийг тодорхойлжээ.

Мастер төлөвлөгөөг хүлээлгэн өгснөөс хойш 3 жилийн дотор дэд бүтэц хөгжөөгүй, алслагдмал нутагт 123,4 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар эрчим хүч, дулаан, зам, тээвэр, харилцаа холбоо, агуулах, худалдааны барилга, байгууламжийн бүтээн байгуулалт хийгдэж, түүнтэй зэрэгцэн 62 нэр төрлийн бараа эргэлт 101,2 сая ам.долларт хүрэх зорилтыг мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн нь хэрэгжих үндэслэл муутай байна.

Чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө хэрэгжсэнээр Монгол Улсын эдийн засагт гарах үр дүнг:

- *бүс нутгийн хүн амын болон үйлдвэр аж ахуйн хэрэгцээний хангалт сайжирна;*
- *бүс нутагт бүтээн байгуулалт өрнөж, бараа, үйлчилгээний эргэлт хурдасч, тоо хэмжээ нэмэгдэж, эдийн засгийн чадавхи нэмэгдэнэ*
- *ажилгүйдэл эрс буурна*

гэж тодорхойлсон нь нарийвчилсан тооцоо судалгаагүй, хэтэрхий ерөнхий болжээ.

“Замын-Үүд” ЭЗЧБ

"Замын-Үүд" ЭЗЧБ-ийг байгуулж, хөгжүүлэх, үйл ажиллагааг нь менежментийн гэрээгээр хэрэгжүүлэхээр шалгарсан "West Paradise" компани менежментийн гэрээний үндсэн дээр 2004-2015 онд нийт 10 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхээр мастер төлөвлөгөө боловсруулжээ.

"Замын-Үүд" ЭЗЧБ-ийн дэд бүтцийн барилга, байгууламжид тус компаниас оруулсан нийт хөрөнгө оруулалтыг Монгол Улсын Засгийн газрын оруулсан хөрөнгөд тооцож, уг хөрөнгийн хэмжээгээр менежментийн гэрээ хэрэгжүүлэгчийн дүрмийн санд Монголын талын эзэмших хувь хэмжээг тогтоох бөгөөд менежментийн гэрээ хэрэгжүүлэгчийн гаргасан хөрөнгийг Монголын тал жил бүр өөрт ногдох ашгаасаа төлөхөөр тохиролцон гүйцэтгэгч компанитай менежментийн гэрээ байгуулжээ.

Эхний үе шатны хөрөнгө оруулалт 698,0 сая ам.доллар байх ёстой бөгөөд төлөвлөгөөний дагуу газар шороо, зам засварын ажил, элсний нүүдлээс хамгаалах далан, ЗАА, хил, гаалийн барилга байгууламжууд баригдах байсан боловч энэ хугацаанд ажил огт хийгдээгүй байна.

Аудитын дүн

Чөлөөт бүсийн удирдлага үр ашигтай, үр нөлөөтэй ажиллаж буй эсэх

“Алтанбулаг” ХЧБ

Чөлөөт бүсийн тухай хуульд зааснаар чөлөөт бүсэд төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч нь чөлөөт бүсийн захирагч байх бөгөөд чөлөөт бүсийн захирагчийг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлнө. Чөлөөт бүсийн захирагч ажлаа Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө хариуцан, чөлөөт бүсэд аж ахуйн удирдлагын чиг үүрэг гүйцэтгэх албан тушаалтан болох ерөнхий менежерийг томилж, чөлөөлөх ёстой ажээ.

Гэтэл “Алтанбулаг” ХЧБ байгуулах шийдвэр гарснаас хойш 3 жил гаруй хугацаа өнгөрөөд байгаа боловч захирагч нь томилогдоогүй бөгөөд 2004 оны 8 дугаар сараас ҮХ-ны сайдын тушаалаар ерөнхий менежерийг томилж, ҮХ-ны сайдын 2005 оны 6 дугаар тушаалаар “Алтанбулаг” ХЧБ-ийн ЗАА-ны бүтцийг баталснаар тус алба 2 хэлтэс, 2 тасаг, 21 ажилтантай ажиллаж байна.

Чөлөөт бүсийн тухай хуульд зааснаар Чөлөөт бүсийн захирагч чөлөөт бүсийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэгтэй. Гэтэл захирагч томилогдоогүйгээс энэ чиг үүрэг өнөөгийн байдлаар ҮХЯ-ны хэлтэст харьяалагдаж, аливаа асуудал боловсруулах, шийдвэрлэх, шийдвэр гаргуулах явцад шат дамжлага ихэсч, цаг хугацаа алддаг байдал ажиглагдаж байна.

СЭЗ-ийн сайд, ҮХ-ны сайдын 2003 оны 256/138 дугаар тушаалаар тус чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөө, Алтанбулаг тосгоны ерөнхий төлөвлөгөө боловсруулах, дэвсгэр зураг, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын хөлсөнд шаардагдах 275 сая төгрөгийг чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын төслийн хөрөнгөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр төсвийн богино хугацааны зээлээр санхүүжүүлж, чөлөөт бүсийн ЗАА-нд олгожээ.

ХЧБ-ийн хөрөнгө оруулалтын сурталчилгааны материалыг “Тоонот принт” ХХК, “Эбо холдинг” ХХК, “Соёмбо принт” ХХК, ГТХЭГ-аар хэвлүүлэхдээ холбогдох хуулийн дагуу тендер шалгаруулалт явуулалгүй 37,0 сая төгрөг зарцуулжээ.

620 сая төгрөгийн өртөгтэй чөлөөт бүсийн хамгаалалтын хашаа, гол хаалга, шалган нэвтрүүлэх болон харуулын байрны байгууламжийг барих ажлын зураг төсвийг “Аксиом констракшн” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэгчээр “Баярс констракшн” ХХК-ийг сонгон шалгаруулж, барилгын ажлыг 2005 оны 7 дугаар сард хүлээн авахаар гэрээ байгуулсан ч 12 дугаар сард хүлээлгэн өгчээ.

Боловсруулсан зураг төсөвт бодит нөхцөл байдлыг буруу тооцоолсон, захиалагч ХЧБ-ийн ЗАА холбогдох байгууллагуудтай

Аудитын дүн

урьдчилан бүрэн ойлголцоогүй байсан зэрэг шалтгаанаас гүйцэтгэх ажлын явцад нэмэлт ажил нилээд хийгдсэн, зарим үед хийсэн ажлыг дахин өөрчилж хийлгэж байсан зэргээс хугацаа алдаж, нэмэлт ажилд 78,5 сая төгрөгийн зардал гаргасан болохыг гүйцэтгэгч компани тайлбарлаж байна.

Түүнчлэн Алтанбулаг сумын төвийн айл өрхийн ундны усны хэрэгцээг хангадаг “Алтанбулаг” булгийн эх тус ХЧБ-ийн хашааны хүзүүвчний гадна хэсэгт хилийн зурвас талд байдаг бөгөөд усны урсгалын гольдрол тус хүзүүвч хэсгийг хөндлөн огтолж, сумын нутаг дэвсгэр лүү урсаж байгааг зохистой шийдвэрлэхгүй бол зөвхөн хамгаалалтын хашаа төдийгүй зам, барилга байгууламжийн ажлыг эвдэлж, сүйтгэх, булгийн усны ундарга бохирдох, экологийн тэнцвэр алдагдах зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй байна.

Гэтэл энэ талаар “Алтанбулаг” ХЧБ-ийн ЗАА-аас боловсруулсан ажлын даалгавар, “Аксиом констракшн” ХХК-ний боловсруулсан хашааны зураг, төсөвт огт тусгагдаагүй байсан бөгөөд “Газар эко” ХХК 2003 онд Чөлөөт бүсийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийхдээ ч мөн орхигдуулсан байна.

“Алтанбулаг” ХЧБ-ийн ЗАА-ны нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, холбогдох маягт, бүртгэлийн данс, журналыг бүрэн хөтлөөгүй байна. Холбогдох баримтын бүрдэл дутуу байхад болон хуулбарласан баримтаар төлбөр хийх, мөнгө олгох явдал нилээд байжээ.

Санхүүгийн удирдлагыг хангалтгүй хэрэгжүүлж, үр ашиггүй зардал гаргаж байжээ. Тухайлбал, 2003 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 100 км-т 22 литр шатахуун зарцуулдаг, 6 цилиндр бүхий хөдөлгүүртэй, 1991 оны “Pontiac” маркийн автомашиныг 1,3 сая төгрөгөөр худалдан авсан бөгөөд 2 жилийн хугацаанд уг автомашины засвар, үйлчилгээнд 4,1 сая төгрөгийн нэмэлт зардал гаргажээ. Түүнчлэн автомашинд олгосон шатахууны зарцуулалтын гүйцэтгэлийг тооцолгүй, шууд зарлага болгож иржээ. Тухайлбал, 2004 онд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум руу 12 удаа томилолтоор яваад ирэхэд шатахуунд 1331540 төгрөг олгож, зардалд бүртгэжээ.

2004 он болон 2005 оны эхний хагас жилд “Алтанбулаг” ХЧБ-ийн ажиллагсад нийтдээ 27 удаагийн томилолтоор 9434 хүн/өдөр Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд ажиллажээ. Албан томилолтоор ойр ойрхон олон хүнийг хамтад нь, ихэнх тохиолдолд батлагдсан удирдамжгүй ажиллуулсан нь нэг талаар ажлын зохион байгуулалт тааруу, нөгөө талаар төсвийн хөрөнгийг арвигч хямгач бус, үр ашиггүй зарцуулж ирснийг харуулж байна.

СЭЗ-ийн сайдын 2001 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах, санхүү-

жүүлэх, тайлагнах журам"-ын 2.5-д "Тухайн төсөвт байгууллагын сайд, дарга нь өөрийн аппаратын болон тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, харьяа байгууллагынхаа ажилтнуудын гадаад оронд явах ажлын зорилго, хугацаа, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг заасан шийдвэр гаргана" гэж заасныг ҮХЯ зөрчиж иржээ.

Тухайлбал "Алтанбулаг" ХЧБ-ийн ЗАА-наас 15 удаа 24 хүнд (давхардсан тоогоор) гадаад албан томилолтын зардалд 22832,2 мянган төгрөг олгосноос 2 нь сайдын тушаалтай, бусад нь албан ёсны тушаал шийдвэргүй, зөвхөн ТНБД-ын баталсан төсвийг үндэслэн гадаад албан томилолтын зардлыг олгож байжээ.

"Замын-Үүд" ЭЗЧБ

Засгийн газрын 2004 оны 45 дугаар тогтоолоор "Замын-Үүд" ЭЗЧБ-ийн ЗАА-ыг байгуулж, 2005 оны 9 дүгээр сард Ерөнхий сайдын захирамжаар тус ЭЗЧБ-ийн захирагч томилогджээ.

ҮХ-ны сайдын 2004 оны 53 дугаар тушаалаар "Замын-Үүд" ЭЗЧБ-ийг байгуулж хөгжүүлэх, үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах тендерийн комиссыг, 61 дүгээр тушаалаар шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг тус тус баталжээ.

Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан "Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам"-ын 3.15-т "... тендерийн хорооны даргаас бусад гишүүнийг үнэлгээний хэсгийн гишүүнээр томилж болно..." гэж заасныг эдгээр тушаал зөрчиж, тендерийн комиссын дарга, шинжээчдийн багийн ахлагчаар ҮХ-ны дэд сайд О.Эрдэнээг нэгэн зэрэг томилжээ. Мөн "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмын тухай" хуулийн 40.3-д "тендерийн хорооны дарга үнэлгээний хэсгийн үйл ажиллагаанд оролцохгүй" гэж заасантай зөрчилдөж байна.

Тендерийн хорооны дарга, шинжээчийн багийн ахлагч нь нэг хүн байснаас шалтгаалан тендерийн хороо, үнэлгээний хэсгийн хуралдаан хамт хийгдэж байсан бөгөөд хуралдааны тэмдэглэлд бусад гишүүдийн санал бодол тусгагдаагүй, зөвхөн хэлэлцсэн асуудал болон гаргасан шийдвэрийг тэмдэглэсэн нь "Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам"-ын 3.21-т "... тендерийн хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө..." гэж заасныг зөрчжээ.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсны дараа 2004 оны 8 дугаар сард анхан шатны шалгаруулалтад тэнцсэн "FTZD" консорциум Засгийн газар болон бүх шатны шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргаснаас 2005 оны 10 дугаар сарыг хүртэл нэг жилийн хугацаанд гүйцэтгэгч компани ажлаа эхэлж чадаагүй байна.

Аудитын дүн

Төлөвлөгөөний эхний үе шатанд ЭЗЧБ-ийн ЗАА дараах ажлыг хийж гүйцэтгэх үүрэг хүлээжээ:

- Чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө, ерөнхий болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, дизайнтай танилцаж, санал дүгнэлт өгөх,
- Бүтээн байгуулалт, газар шорооны ажлыг эхлүүлэх,
- Чөлөөт бүсэд мөрдөгдөх дүрэм, журмуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулах.

Гэвч боловсруулсан мастер төлөвлөгөө, ерөнхий болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодорхой санал дүгнэлт хийгээгүй, чөлөөт бүсийн хашаа хүртэлх газарт дэд бүтцийн асуудлыг шийдвэрлүүлээгүй, чөлөөт бүсэд мөрдөгдөх дүрэм, журмуудыг боловсруулж дуусаагүй байна.

“Замын-Үүд” ЭЗЧБ-ийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор ҮХ-ны сайдын 2004 оны 30 дугаар тушаалаар Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн өмчлөлд байгаа Замын-Үүд сум дахь 8 айлын орон сууцны барилгыг “Замын-Үүд” ЭЗЧБ-ийн ЗАА-нд ашиглуулахаар шийдвэрлэжээ.

Энэ шийдвэрийн дагуу тус ЭЗЧБ-ийн ЗАА уг барилгыг хүлээн авч, засвар, халаалтын зардалд 6,8 сая төгрөг зарцуулаад байгаа боловч оршин суугчид нь гарахгүй байгаагаас барилгыг бүрэн ашиглаж чадахгүй, шийдвэр хэрэгжихгүй байна.

Чөлөөт бүсийн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн эсэх

УИХ-ын 1995 оны 87 дугаар тогтоолоор “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал” (цаашид “үзэл баримтлал” гэнэ)-ыг баталж, Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулахад баримтлах зарчмыг тодорхойлжээ. Үүнд, эхний ээлжинд Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудал болон улсын хил орчмын нутагт “Худалдааны чөлөөт бүс”-ийг энгийн хэлбэрээр бий болгож, зохих туршлага хуримтлуулсны үндсэн дээр эдийн засгийн чөлөөт бүсийг нутгийн гүнд үйлдвэрлэл, худалдаа хосолсон хэлбэрээр, үе шаттай хөгжүүлэхээр тусгасан байна.

1996 оноос яригдсан “Алтанбулаг” ХЧБ-ийн үйл ажиллагаа эхлээгүй, хөрөнгө оруулагч нь тодроогүй байхад “Замын-Үүд” ЭЗЧБ болон “Цагааннуур” ХЧБ байгуулах хууль баталж, хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулалт зэрэг зарим үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа төдийгүй, Чойрын чөлөөт бүс байгуулах асуудлыг ч мөн ярьж эхэлж байна.

Үзэл баримтлалд тодорхойлогдсон чөлөөт бүс байгуулах зорилтыг хангахын тулд бүрдүүлсэн байх эдийн засаг, зохион байгуулалтын 5 угтвар нөхцөл хэрхэн хангагдсан байдлыг авч үзэхэд:

Аудитын дүн

Бүрдүүлсэн байх угтвар нөхцөл	“Алтанбулаг” ХЧБ	“Замын-Үүд” ЭЗЧБ
- Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн холбоо, эрчим хүч, зам тээвэр зэрэг үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтэц шинээр бүрдүүлэх буюу сайжруулах	- Хэрэгжээгүй	- Хэрэгжээгүй
- Чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж, байгууллага чөлөөтэй, итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин нөхцөл бий болгох;	- Бүрэн хангагдаагүй	- Бүрэн хангагдаагүй
- Гадаадын хөрөнгө оруулагчидтай харилцаа тогтоосон, чөлөөт бүсэд хөрөнгө оруулах баталгаатай, бизнесийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах чадвартай компаниуд бий болгох;	- Хэрэгжиж байгаа	- Хэрэгжиж байгаа
- Худалдаа, бизнесийн үйл ажиллагаанд мэргэшсэн буюу энэ төрлийн ажил хийх сонирхол, мэргэжлийн ур чадвар сайтай, үйлчилгээний өндөр соёл эзэмшсэн ажиллах хүч бий болгох;	- Хэрэгжээгүй	- Хэрэгжээгүй
- Чөлөөт худалдааны төв, гаалийн баталгаат агуулах, хил, гаалийн шалган нэвтрүүлэх цогцолбор, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, банк, зочид буудал, үйлчилгээний бусад цэг, салбар байгуулах талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ, хэлцэл хийсэн байх.	- Хэрэгжээгүй	- Бүрэн хангагдсан

Нэгтгэсэн дүн

“Алтанбулаг” ХЧБ

- Бүрэн хангагдсан - 0
 - Бүрэн хангагдаагүй - 1
 - Хэрэгжиж байгаа - 1
 - Хэрэгжээгүй - 3

“Замын-Үүд” ЭЗЧБ

- Бүрэн хангагдсан - 1
 - Бүрэн хангагдаагүй - 1
 - Хэрэгжиж байгаа - 1
 - Хэрэгжээгүй - 2

Үүнээс үзэхэд Монгол Улсад чөлөөт бүс байгуулах угтвар нөхцөл бүрэн хангагдаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2005 оны 70 дугаар захирамжаар чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах журмуудыг боловсруулахаар ҮХ-ны Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийг томилж ажиллуулжээ.

Ажлын хэсэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулахдаа:

- Чөлөөт бүсийн Захирагчийн эрх, хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Олон улсын байгууллагаас тавьсан шаардлагад нийцүүлэх;
- Төрийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох;
- Чөлөөт бүсэд татварын болон хөнгөлөлт, чөлөөлөлтийн нэгдсэн тогтолцоо бий болгох

зарчмыг баримтлан, чөлөөт бүсэд захирагч эрх зүйн тусгай дэглэм тогтоож, чөлөөт бүсийн үйл ажиллагаанд төрийн захиргааны байгууллагын оролцоог аль болох бага байлгах болон гадаадын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хангуулах чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулсан байна.

Харин чөлөөт бүсийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах журмуудыг боловсруулах ажил удаашралтай байна.

Дүгнэлт

Монгол Улсад чөлөөт бүс байгуулах ажлын явц, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-д тодорхойлсон чөлөөт бүс байгуулах зорилтыг хангахын тулд бүрдүүлсэн байх эдийн засаг, зохион байгуулалтын угтвар нөхцөл бүрэн хангагдаагүй, “... эхний ээлжинд худалдааны чөлөөт бүсийг энгийн хэлбэрээр бий болгож, зохих туршлага хуримтлуулсны үндсэн дээр, ... үе шаттай хөгжүүлэх” зарчим хэрэгжээгүй байна.
- “МИПС” ХХК гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй, хугацаа хоцроосон байхад ҮХЯ болон “Алтанбулаг” ХЧБ-ийн удирдлага хариуцлага тооцож, зөрчлийг арилгуулалгүй, гэрээт ажлыг хүлээн авч 185,0 сая төгрөг төлжээ.
- “Алтанбулаг” ХЧБ-ийн мастер төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зорилтууд хэрэгжих үндэслэл муутай байна.
- “Алтанбулаг” ХЧБ-ийн хамгаалалтын хашаа, гол хаалга, шалган нэвтрүүлэх болон харуулын байрны байгууламжийн зураг төсвийг захиалах, хүлээн авахад ЗАА хариуцлагагүй хандсан байна.
- ҮХЯ гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах, санхүүжүүлэхдээ холбогдох дүрэм журмыг баримтлаагүй байна.
- “Алтанбулаг” ХЧБ-ийн ЗАА төсвийн хөрөнгийг арвич хямгач бус, үр ашиггүй зарцуулж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлтийг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Тайлбар 1.1 -ийг харна уу.

Засгийн газар болон Үйлдвэр, худалдааны яам хөрөнгө санхүүжилтын асуудлыг шийдвэрлэж чадалгүй цаг хугацаа алдаж, төлөвлөгөөг боловсруулж дуусган хүлээлгэн өгөхөд бэлэн байсан МИПС ХХК-д гүйцэтгэлийн төлбөрийг цаг хугацаанд нь шилжүүлээгүй тул уг компани нь Захирагчийн ажлын албанд дээрхи төлөвлөгөөнүүдийг зөвхөн хөрөнгийг шийдвэрлэсэн Санхүү эдийн засгийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын хамтарсан тушаал гарсны дараа хүлээлгэн өгсөн нь алданги тооцох нөхцөл болох боломжгүй юм. Мастер төлөвлөгөө, Ерөнхий төлөвлөгөөнүүдийг цаг хугацаанд нь нийлүүлээгүйгээс шалтгаалан чөлөөт бүс байгуулах бүтээн байгуулалтын ажилд аливаа хүндрэл учраагүй болно.

2004 оны 2 дугаар сарын 4-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн Мастер төлөвлөгөөг хэлэлцээд сайшаан дэмжиж төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийн хүрээнд хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах тендер зарлах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгасан.

Тайлбар 1.2 -ыг харна уу.

“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хамгаалалтын хашаа, гол хаалга, шалган нэвтрүүлэх болон харуулын байрны байгууламжийн зургийн уралдааныг төвийн хэвлэлээр зарлаж сонгон шалгаруулалтанд түрүүлсэн АКЦИОМ ХХК-аар зураг төсвийг гүйцэтгүүлэн Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газраар улсын экспертизийн дүгнэлт гаргуулсан. Нэгэнт барилгын зураг төсвийг хянах мэргэжлийн байууллагаас “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн харуул хамгаалалтын байгууламжийн зураг, ажлын төсвийг хянан шалгаж дүгнэлтээ гаргаж ирүүлсэн тул Захирагчийн ажлын алба экспертизийн дүгнэлтийг үндэслэн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж уг байгууламжийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болно.

“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь улсын төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах талаар оновчтой зохион байгуулалтыг шат дараалан авч ажиллаж ирсний үр дүнд 2003, 2004 оны санхүүгийн тайлан балансын дүнгээр цалингийн сан болон урсгал зардлыг 20-40 сая төгрөгөөр хэмнэж үр ашигтай зарцуулж ирсэн. Аудитын шалгалтаар нягтлан бодох бүртгэл хөглөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар илэрсэн зөрчил дутагдалыг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээг цаашид анхаарч ажиллах болно.

Дээрхи тайлбаруудтай холбогдол бүхий зарим нэмэлт баримт материалыг хавсарган хүргүүлэв.

“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба

2006 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр

3. "Замын-Үүд" ЭЗЧБ-ээс ирүүлсэн санал



"ЗАМЫН ҮҮД" ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас/Факс: 31-81-88, E-mail: info@zamiynuud.mn
Http://www.zamiynuud.mn

2006.01.10 № 1/2
танай 2005.12.29 -ны № 3/349 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА О. МЭНДБАЯР ТАНАА

Монгол улсад чөлөөт бүс байгуулах ажлын
явц, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгах саналаа
хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: 2 хуудас.



ЗАХИРАГЧ

Я. ГАНТӨМӨР

080059

Тайлбар 2.1 -ийг
харна уу.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТАЛААРХ ЗАРИМ САНАЛ

1. Чөлөөт бүсийн хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай.

Хуулийн үзэл баримтлал 1995 онд, Чөлөөт бүсийн тухай хууль 2002 онд тус тус батлагдсан. Тухайн үед зарим орны түүний дотор БНХАУ-ын чөлөөт бүсийн туршлагыг судалж гааль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг чөлөөт бүсийн хуульдаа тусгаж байсны зэрэгцээ чөлөөт бүс гэдэг ойлголтыг Гаалийн тухай хуульд тодорхойлсон гаалийн бүс гэсэн ойлголттой илүү ойртуулж авч үзэж хууль эрхзүйн орчинг боловсруулсан байдаг.

Үзэл баримтлал батлагдсанаас хойшхи 10 жилийн хугацаанд чөлөөт бүсийн тухай ойлголт, ялангуяа төвөөс хамааралтай байх байдлыг багасгаж төвлөрлийг сааруулах, чөлөөт бүсийн захиргаанд түлхүү эрх мэдэл өгөх бие даасан байдлыг хангах чиглэлээр нааштай ажлууд хийгдэж байгаа боловч доорхи асуудлыг төр засгийн хэмжээнд анхаарч ажиллавал бидний ажилд нэн дөхөмтэй байх болов уу.

Нэгд. Чөлөөт бүс нь аж ахуйн үйл ажиллагааны онцлог бөгөөд шинэлэг хэлбэр учраас зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохирсон уян хатан, аль болох хялбар дүрэм, журамтай байх шаардлагатай. Чөлөөт бүсэд бүх талын харьцааг хуульчилбал түүнийг өөрчлөхөд хүндрэлтэй, цаг хугацаа их шаардагддаг тул зонхилох харилцааг нь аль болох чөлөөт бүсэд мөрдөх дүрэм, журмаар зохицуулдаг олон улсын жишиг, туршлага байдаг. Иймд манай чөлөөт бүсүүдийн өрсөлдөх чадварыг сайтар тооцож үзсэн гааль, татварын тусгай дэглэм үйлчлэх шаардлагатай юм.

Хоёрт. Төрийн захиргааны төв байгууллагууд чөлөөт бүсийн харилцааг зохицуулахад байнга оролцож эрх мэдлээ хэрэгжүүлж байх гэсэн сонирхол өндөр байна. Жишээлбэл, гадаадаас ажиллах хүчин, мэргэжилтэн авах хувь хэмжээг тогтоох, ажлын байрны төлбөр болгон сар бүр гадаадын ажилчдаас 85000 төгрөг авах тухай хуулийн заалтыг чөлөөт бүсэд мөрдөхөд

Тайлбар 2.2 -ыг
харна уу.

Улаанбаатарт байгаа Хөдөлмөр, халамжийн газар, НХХЯ, ГИХАЭ Алба зэрэг байгуулагуудаас холбогдох зөвшөөрөл авах шаардлага гарч байгаа юм. Энэ нь хөрөнгө оруулагчдыг залхаах, хүнд сурталыг хөхүүлэх мэтээр чөлөөт бүсийн хөгжилд саад учруулах сул талтай.

Иймээс чөлөөт бүсийн бие даасан байдлыг хангах, удирдлагын ялангуяа Захирагчийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

2. Чөлөөт бүсийн захиргаа байгуулах үед чөлөөт бүсийн Захирагчийг томилж байх шаардлагатай.

Захирагч томилогдоогүйгээс ажил цалгардах, хөрөнгө оруулагчдын зүгээс чөлөөт бүсийн захиргаадыг үл ойшоох хандлага гарч байна.

ҮАГ-ын тайлбар

1. “Алтанбулаг” ХЧБ-ийн ЗАА-ны саналд өгөх тайлбар

Тайлбар 1.1

Аудитаар “Алтанбулаг” ХЧБ-ийн Мастер төлөвлөгөө болон Ерөнхий төлөвлөгөө, Алтанбулаг сумын Ерөнхий төлөвлөгөө боловсруулах 200,0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээт ажлын биелэлтийг шалгаад гүйцэтгэгч “МИПС” ХХК-д гэрээний нөхцөлийн дагуу 49,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосонтой холбогдуулж ирүүлсэн тайлбарт дараахь хариу өгч байна.

1. Тайлбарт дурдсанчлан гүйцэтгэгч компани хөрөнгийн асуудлыг шийдэгдтэл гэрээт ажлыг хүлээлгэн өгөхийг хойшлуулж байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй юм. Учир нь ҮХЯ болон ЗАА гэрээт ажлыг хүлээн авахдаа гүйцэтгэгчийн гэрээний нөхцөлийн дагуу холбогдох гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагуудын үнэлэлт, дүгнэлтийг гаргуулсан байх ёстой. Гэтэл Дэд бүтцийн сайдын 2003 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 173 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн экспертизийн дүгнэлт 10 дугаар сарын 15-нд гарсан байна.
2. Төлбөрийн акт тогтоосон нь гүйцэтгэгч компаниас Мастер төлөвлөгөө болон Ерөнхий төлөвлөгөөнүүдийг цаг хугацаанд нь хүлээлгэн өгөөгүйгээс чөлөөт бүс байгуулах бүтээн байгуулалтын ажилд нөлөөлсөн эсэхтэй огт холбоогүй бөгөөд зөвхөн 2 талын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ногдвол зохих төлбөрийн хариуцлагыг нөхөн тооцсон болно.

Тайлбар 1.2

“Алтанбулаг” ХЧБ-ийн ЗАА нь тус чөлөөт бүсийн хамгаалалтын хашаа, гол, хаалга, шалган нэвтрүүлэх болон харуулын байрны байгууламжийн зураг төсвийн ажлын захиалгыг боловсруулж, зураг төсвийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ирсэн тул тухайн ажлын чанар, үр дүн тус ЗАА-тай зайлшгүй холбоотой гэж аудитын баг үзсэн.

**1. “Замын -Үүд”
ЭЗЧБ-ийн ЗАА-
ны саналд
өгөх тайлбар**

Тайлбар 2.1

Ирүүлсэн тайлбарт дурдагдсан саналууд нь чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах журмуудыг боловсруулахаар МУ-ын Ерөнхий Сайдын 2005 оны 70 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд бүрэн тусгагдсан гэж бид үзэж байна. Холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн талаар аудитын тайланд тодорхой дурдсан болно.

Тайлбар 2.2

Чөлөөт бүсийн захирагчийг хугацаа алдалгүй томилж байх талаар гаргасан саналыг аудитын баг дэмжиж байгаа бөгөөд “Алтанбулаг” ХЧБ-ийн Захирагчийг зохих журмын дагуу томилуулах талаар аудитын зөвлөмжийн 1.2-т тусгагдсан.

Зөвлөмж

Гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

1. Үйлдвэр, худалдааны сайдын үүрэг гүйцэтгэгч С.Батболдод:

- 1.1. “Алтанбулаг” ХЧБ болон “Замын-Үүд” ЭЗЧБ байгуулах ажлыг эрчимжүүлэх;
- 1.2. “Алтанбулаг” ХЧБ-ийн захирагчийг зохих журмын дагуу томилуулан ажиллуулах;
- 1.3. СЭЗ-ийн сайдын тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2. “Алтанбулаг” ХЧБ, “Замын үүд” ЭЗЧБ-ийн Захирагчийн ажлын албадад:

- 2.1. ЗАА-ны санхүүгийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, төсөвт хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай захиран зарцуулж байх;
- 2.2. Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой СЭЗ-ийн сайдын баталсан журам зааврыг мөрдөж, аудитаар илэрсэн дутагдал, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
О. МЭНДБАЯР

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсад чөлөөт бүс байгуулах ажлын явц, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг хавсралтаар баталсугай.

3. Гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий сайд, Үйлдвэр, худалдааны сайд, “Алтанбулаг” Худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, “Замын-Үүд” Эдийн засгийн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2006 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Үйлдвэр, худалдааны сайдын үүрэг гүйцэтгэгч С.Батболд, “Алтанбулаг” Худалдааны чөлөөт бүсийн Ерөнхий менежер Н.Ханой, “Замын-Үүд” Эдийн засгийн чөлөөт бүсийн Захирагч Я.Гантөмөр нарт зөвлөсүгэй.

5. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын хоёрдугаар хэлтсийн дарга О.Мэндбаярт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА